ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 05 өдөр Дугаар А/13 Гучин-Ус сум

Зөөврийн карказ хийх ажлыг сонгон
шалгаруулах үнэлгээний хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, 50.5, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зөөврийн карказ хийх ажлыг сонгон шалгаруулах 29,900,000 (хорин есөн сая есөн зуун мянга) төгрөгийн ажлын тендерийг шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Т.Нэргүй (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)
Гишүүн:	Г.Пүрэвжаргал (Цэцэрлэгийн багш)
Хараат бус гишүүд:	Д.Болорчимэг (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)
	Ө.Бадамзул (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)
Нарийн бичиг:	У.Лхамдэгд (архив, бичиг хэргийн эрхлэгч)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж мэдэгдэл, гэрээний төслийг ергөн мэдүүлэхийг Үнэлгээний хорооны дарга (Т.Нэргүй)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, архив бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (У.Лхамдэгд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Х.ӨНХТАЙВАН

My doc.G.Zahiramj